

11-Р АНГИЙН ГАЗАРЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Овог Нэр..... Анги.....

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Нийт 66 оноо

1. Зурагт өгөгдсөн диаграммын онцлогийг тодорхойл? /1 оноо/



- A. Шаталсан түвшин бүртээ өөр өөр утгыг харуулдаг олон шатлал бүхий цацраган диаграмм
 B. Юмс үзэгдлийн бүтэц, бүрэлдэхүүн буюу бүхэл зүйлийн доторх хуваагдсан хэсгүүдийг үзүүлсэн тойргон диаграмм
 C. Хувьсах хэмжигдэхүүнүүд хоорондоо хэрхэн хамаарч өөрчлөгдөж байгааг харуулсан бөмбөлгөн диаграмм
 D. Хоорондоо хамаарал бүхий 2-оос дээш үзүүлэлтийг нэгтгэн харуулдаг цэгэн тархалтат диаграмм
2. Дараах тодорхойлолтуудыг зөв харгалзуулсан хариултыг сонгоорой. /1оноо/


1. Газарзүйн мэдээллийн систем	а. Аливаа биет, үзэгдлээс ойсон болон цацарсан долгионыг хэмжиж зурагладаг арга
2. Зайнаас тандан судлал	б.Байршилтай холбоотой дүн шинжилгээ хийдэг компьютержсэн мэдээллийн систем
3. Google Earth	с. Хиймэл дагуулын зураглал ашиглан бүтээсэн интернет газарзүйн мэдээллийн систем

- A. 1а, 2б, 3с B. 1б, 2с, 3а C. 1с, 2а, 3б D. 1б, 2а, 3с

3. Дараах график, диаграммын өгөгдлийг харьцуулан тооцоолж хүн амын өсөлт 0.43%, хүн амын тоо 234.9 (мян)-аар өссөн онуудыг сонгоно уу? /1 оноо/

- A. 2010, 2011

Монгол Улсын хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь



- B. 2011, 2012
- C. 2013, 2014
- D. 2010, 2014

4. Дараах Монгол

орны хүн амын өсөлтийг харуулсан хүснэгтэн мэдээллээс 1963 ба 1969 оныг харьцуулан, ажиглалт хийх бол аль арга нь тохиромжтой вэ? /1оноо/

Он	1935	1944	1956	1963	1969	1979	1989	2000	2001
Өсөлт	3.1	4.3	18.1	32.7	27.9	28.4	27.1	14.0	19.3


- A. Тойргон диаграмм
- B. Гурвалжин диаграмм
- C. Баганан диаграмм
- D. Аалзны торон диаграмм

5. Улс орнуудын хөгжлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /1 оноо/

1. Эдийн засгийн үзүүлэлт	a. Эрүүл мэндийн байдал
2. Нийгмийн үзүүлэлт	b. Нэг хүнд ноогдох ДНБ
3. Хүн амзүйн үзүүлэлт	c. Эрүүл орчин, ахуй нөхцөл
4. Ардчиллын хөгжлийн шалгуур	d. Хүний сонголт хийх боломж

- A. 1d, 2a, 3b, 4c
- B. 1a, 2b, 3c, 4d
- C. 1b, 2c, 3a, 4d
- D. 1b, 2a, 3c, 4d

6. Хөгжингүй орнуудын “Орлогын өөрчлөлт ба аз жаргалын индекс”-ийг харуулсан графикийг зөв дүрсэлсэн хариултыг сонгоно уу? /1 оноо/



- A. Хүн амын орлого ба аз жаргалын индекс буурсан
- B. Хүн амын орлого өсөж, аз жаргалын индекс буурсан
- C. Хүн амын орлого ба аз жаргалын индекс өссөн
- D. Хүн амын орлого өсөж, аз жаргалын индекс тогтмол

7. Норвеги улс нь газрын тосны баялаг нөөцтэй “Хойд тэнгис”-ийг эзэмшсэн нь хүний хөгжлийн индексээр дэлхийд тэргүүлэх болсон шалтгаан дангаараа мөн үү ? Үгүй бол ямар хүчин зүйл нөлөөлсөн байж болох вэ? /1 оноо/
- A. Цагаан будаа тариалалтаар тэргүүлдэг
 - B. Суудлын машин үйлдвэрлэлтээр тэргүүлдэг
 - C. Үхрийн тоогоор тэргүүлдэг
 - D. Далайн хүнсний экспортоор тэргүүлдэг

8. Даяаршлын ангиллыг жишээтэй зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /1 оноо/


1. Эдийн засгийн даяаршил	a. Олон улсын чөлөөт худалдаа
2. Улс төрийн даяаршил	b. ТВ багц суваг ашиглах (HBO)
3. Нийгмийн даяаршил	c. ASEM-ийн дээд хэмжээний уулзалт
4. Соёлын даяаршил	d. Үндэсний сагсан бөмбөгийн холбоо (NBA)

- A. 1d, 2a, 3b, 4c B. 1a, 2b, 3c, 4d C. 1b, 2c, 3a, 4d D. 1a, 2c, 3b, 4d

9. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу?гол үзэл санаа нь төвлөрлийг сааруулах, бүс нутаг, улс үндэстэн, орон нутгийн хөгжлийг дэмжих, тэдгээрийн бие даасан байдлыг хангахад чиглэнэ. /1 оноо/


- A. Даяаршлын
- B. Дангаарчлалын
- C. Үндэстэн дамнасан корпорацийн
- D. Аутсорсингийн

10. Судан улс хүн ам зүйн нөхөн үйлдвэрлэлийн I үе шатанд хамаарагддаг. Зураг ашиглан зөв хариултыг сонгоно уу? /1оноо/




- A. Төрөлт, нас баралтын их
- B. Нас баралт их, хүн амын өсөлт их
- C. Төрөлт их, хүн амын өсөлт их
- D. Төрөлт, нас баралт бага

11. “J” хэлбэрээр дүрсэлсэн дэлхийн хүн амын өсөлтийн зургийг ашиглан зөв хариултыг сонгоно уу? /1 оноо/




- A. Хүн ам 200-1600 онд огцом өссөн
- B. Хүн ам 1800 оноос хойш огцом өссөн
- C. Хүн ам 1800 оноос удааширсан
- D. Хүн ам 1600 оноо хойш огцом буурсан

12. Хүн амын төрөлт, нас баралтыг улс орнуудын хөгжлийн түвшингээр харуулжээ. Графикийг харьцуулж ялгааг зөв тодоройлсон хариуг сонгоно уу? /1 оноо/




- A. 2000 оны хөгжиж буй орнуудын төрөлт нь хөгжингүй орнуудынхаас их байна
- B. 1975 оны хөгжиж буй орнуудын төрөлт нь хөгжингүй орнуудынхаас бага байна
- C. 1950 оны хөгжиж буй улс орнуудын ердийн өсөлт хөгжингүй орнуудынхаас бага байна
- D. 1800 оны хөгжиж буй орнуудын төрөлт хөгжингүй орнуудынхаас бага байна

13. АНЭУ-ын хүн амын суварган диаграммыг ажиглаж ямар насны, ямар хүйсийн хүмүүс хамгийн их тоог эзэлж байна вэ ? /1 оноо/




- A. 30-34 насны эмэгтэй
- B. 30-34 насны эрэгтэй
- C. 20-25 насны эрэгтэй
- D. 20-24 насны эмэгтэй

14. Дараах хүн амын суваргыг ажиглаж 16.8 хувиар өсөх хандлагатай насны ангиллыг сонгоно уу /1 оноо/



- A. 75-80 насныхан
- B. 50-55 насныхан
- C. 40-45 насныхан
- D. 5-10 насныхан

15. Дараах зурагт ямар арьстны тархалтыг тодруулж будсан байна вэ? /2 оноо/



- A. Европ төрхийн буюу цагаан
- B. Монгол төрхийн буюу шар
- C. Негр төрхийн буюу хар
- D. Австрали төрхийн

16. Дараах зургийг ажиглаж ямар хэлний бүлэгт хамаарах улсуудыг тодоор будаж харуулсан байна вэ? /2 оноо/




- A. Энэтхэг-Европ хэлний бүлэг
- B. Хятад Төвд хэлний бүлэг
- C. Түрэг хэлний бүлэг
- D. Алтайн Язгуур хэлний бүлэг

17. Шилжих хөдөлгөөний татагч хүчин зүйлийг сонгоно уу? /2 оноо/

- A. Эрүүл мэндийн чанартай үйлчилгээ
- B. Ажлын байрны хомсдол
- C. Байгаль орчны бохирдол
- D. Байгалийн гамшиг

18. Хөдөлгөөнт шугамын аргаар үзүүлсэн дараах зургаас хамгийн олон хүн хаанаас хаашаа чиглэсэн шилжих хөдөлгөөн хийсэн бэ? /2 оноо/



- A. Европоос-АНУ, Латин Америк руу
- B. Африкаас-Латин Америк, Хойд Америк руу
- C. Өмнөд Азиас- Европ, Африк руу
- D. Европоос- Зүүн Ази, Африк руу

19. Үйлдвэрлэлийн гуравдагч хэв шинжид хамаарах салбар аль нь вэ?


- A. Уул уурхай олборлолт
- B. Үйлчилгээ
- C. Түүхий эд бэлтгэх
- D. Техник технологи

20. Хотжилтын түвшинг нийт хүн амын дотор хотын оршин суугчдын эзлэх хувийн жингээр тодорхойлдог. Хүснэгтэн мэдээллээс хотжилтын түвшинг зөв тодорхойлсон хариултыг сонгоно уу? /1 оноо/

Улсын нэр	Нийт хүн амын тоо (сая)	Хөдөөгийн хүн ам (сая)	Хотын хүн ам (сая)	Хотжилтын түшин
Кени	45.0	35.1	?	?

- A. 22%
- B. 32%
- C. 42%
- D. 52%

21. Гадаргын гүдгэр хэлбэрийг тодруулж будсан дараах зурагт хот хүрээгээ тэлж, өргөжих боломжтой байж болох чиглэлийг сонгоно уу? /1 оноо/



- A. Баруун ба өмнөд чиглэлд
- B. Баруун ба зүүн чиглэлд
- C. Хойд ба өмнөд чиглэлд
- D. Зөвхөн баруун чиглэлд

ө

22. Зургийг ажиглан, хамгийн их ган үйлдвэрлэгч орон болон түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг зөв тодорхойлсоныг сонгоно уу? /1 оноо/

Гангын үйлдвэрлэлээр тэргүүлэгч улс орнууд



- A. АНУ, өндөр технологи
 - B. ОХУ, нөөцийн хэмжээ
 - C. Бразил, геологийн тогтоц
 - D. Хятад, хэрэглээний өсөлт
23. 2019 оны байдлаар дэлхийд газрын тос олборлолтоор АНУ, ОХУ, Саудын Араб, Канад, Ирак улсууд тэргүүлжээ. Газрын тосны олборлолт нь үйлдвэрлэлийн ямар хэв шинжид хамрагдах вэ? /2 оноо/
- A. Гуравдагч
 - B. Хоёрдогч
 - C. Анхдагч
 - D. Дөрөвдөгч
24. Үйлдвэрлэлийн байршилд нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийг сонгоно уу? /2 оноо/
- A. Далайн зам
 - B. Ажиллах хүч
 - C. Хөрөнгө мөнгө
 - D. Зах зээл
25. Сэрүүн уур амьсгалтай ойт хээрийн бүсэд багтах баруун Европын ихэнх орнууд АНУ-н зүүн хойд мужуудад үхрийг голлон сүү, махны чиглэлээр өсгөн үржүүлдгийн шалтгаан юу вэ? /2 оноо/
- A. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ
 - B. Байгаль цаг уурын таатай нөхцөл
 - C. Улс орны хөгжлийн түвшин
 - D. Тэжээл, бордооны төрөл нөөц

26. Дэлхийн бүс нутгийн газар тариаланг борооны усыг ашигладаг ба усалгаатай газар тариалан гэж хоёр ангилдаг. Усалгаа нь дотроо олон төрөлтэй. Дараах усалгааны төрлүүдээс ашигт байдал хамгийн өндөртэйг нь сонгоно уу? /2оноо/ А. Бассейн үүсгэх
 В. Дуслын систем
 С. Шан татах
 D. Бороожуулагч
27. 13 жилийн хугацаанд, 50 мянга орчим ажилчид барьж байгуулан, 13000 км зайг хэмнэдэг, усан замын тээвэрт чухал ач холбогдолтой, Хойд ба Өмнөд Америкийн эх газрыг тусгаарласан сувгийг сонгоно уу? /2оноо/
 А. Суэц
 В. Дрейк
 С. Панам
 D. Гибралтари
28. Дэлхийн нийт ачаа эргэлтийн 61% нь усан замын тээвэрт оногддог. Монгол орны ачаа тээвэрлэлтэд төмөр зам голлох үүрэгтэй бөгөөд 2020онд ачаа эргэлт 19800сая тн км болж өмнөх оноос 10% хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оны ачаа эргэлтийг зөв тооцоолсныг сонгоно уу? /2оноо/
 А. 11780 сая тн.км
 В. 17820 сая тн.км С. 19602 сая тн.км
 D. 18000 сая тн.км
29. Зургийг ажиглаарай. Дэлхий дээрх дурын хоёр цэгийн хоорондох хамгийн богино буюу агаарын дөт замын зураглал гаргахдаа юуг баримжаалдаг вэ? /2 оноо/
 А. Матрын замыг
 В. Их тойргийн нумыг
 С. Мэлхийн замыг
 D. Туйлын цагиргийг



- А. Матрын замыг
 В. Их тойргийн нумыг
 С. Мэлхийн замыг
 D. Туйлын цагиргийг

30. Зургуудыг ажиглан үйлдвэрлэлийн хэв шинжүүдийг харьцуулан үйлдвэрлэлийн дөрөвдөгч хэв шинжийн гол ялгааг сонгоно уу? /1 оноо/

Зураг 1. Далайн тээвэр



Зураг 2. Сандалын шинэ загвар.




- А. Бүтээгдэхүүн тээвэрлэх, нийтийн үйлчилгээ
 В. Бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, бөөний худалдаа
 С. Бүтээгдэхүүн үйлчилгээг судлах, загвар зохион бүтээх
 D. Бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, эмнэлгийн үйлчилгээ

31. Дэлхийн үйлчилгээний салбарын экспортын 31.0 хувь нь аялал жуулчлалын салбарт хамаарагддаг байсан бөгөөд жуулчид хамгийн их зорин очдог Европын улсуудад Франц, Испани, Итали зэрэг улсууд багтдагийн шалтгааныг зөв сонгоно уу? /2 оноо/ А. Авто машины өргөн худалдаа
 В. Бизнесийн таатай нөхцөл
 С. Эрх зүйн таатай орчин
 D. Соёлын өв, далайн эргийн амралт
32. Таны амьдарч буй хотын, агаарын чанарын индексг шар өнгөөр илэрхийлж байвал агаарын чанарын ангиллаар ямар түвшинд байна вэ? /2 оноо/ А. Маш их бохирдолтой
 В. Их бохирдолтой
 С. Дунд зэргийн бохирдолтой D. Хэвийн
33. Диаграммыг ажиглан, гамшигт үзэгдлийн давтамж сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаагийн шалтгааныг сонгоно уу? /2 оноо/




- А. Эдийн засгийн хямрал
 В. Өргөн уудам нутагтай
 С. Уур амьсгалын өөрчлөлт
 D. Хоёр их гүрэнтэй хиллэдэг
34. Дараах үйл явцуудаас, уур амьсгалын өөрчлөлтийг илэрхийлж байгааг нь сонгоно уу? 1 оноо
 А. Цэвдгийн гэсэлт
 В. Өдөр шөнө солигдох
 С. Сар дэлхийг тойрох
 D. Газар хөдлөх
35. Хүн амын хурдтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, хотжилт зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр усны хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байна. Дараах улсуудаас цэвэр усны хомсдолд орж болзошгүй орныг сонгоно уу? /2 оноо/
 А. Канад В.Бразил С. Гренланд D.Саудын Араб
36. Зургийг ажиглан, цэвэр усны нөөц хамгийн ихтэй бүс нутаг, улс орныг сонгоно уу? /1 оноо/



- A. Канад, Хойд Америк
- B. Алжир, Хойд Африк
- C. Швейд, Баруун Европ
- D. Сир, Баруун Өмнөд Ази

37. Хүн амын суваргыг ажиглан дараах асуултанд хариул



- A. Ямар хэлбэрийн суварга вэ?
- B. Ажиллах хүчний нөөц хэрхэн өөрчлөгдөх вэ?
- C. 60-с дээш насныхан хэдэн хувийг эзэлж байна вэ?


38. Дэлхийн дулаарллыг багасгахад та хэрхэн юу хийж чадах вэ?

1.
2.
3.

39. Гуравдагч ба дөрөвдөгч үйлдвэрлэлийн салбарын тус бүр хоёр жишээ нэрлээрэй. Гуравдагч үйлдвэрлэлийн салбар:

Дөрөвдөгч үйлдвэрлэлийн салбар:

40. Хүн амын нягтшилын зургийг ажиглан дараах асуултанд хариул



- A. Аль бүс нутагт хүн ам их суурьшсан байна вэ?
- B. Хүн ам их суурьшсан хүчин зүйлсийг нэрлэнэ үү?

№	Оноо	Зөв хариу
1	1	B
2	1	D

3	1	D
4	1	C
5	1	C
6	1	D
7	1	D
8	1	D
9	1	B
10	1	A
11	1	B
12	1	A
13	1	B
14	1	A
15	2	B
16	2	B
17		A
18		A
19		D
20		A
21		D
22		D
23		C
24		A
25		A
26		B
27		C
28		D
29		B
30		C
31		D
32		D
33		C
34		A
35		C
36		A

37	3	
38	3	
39	3	
40	4	